



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/259

Арвайхээр

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шүүхийн шийдвэрээр хураагдсан автомашин, эд зүйлсэд үнэ тогтоох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: З.Балданням (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)


С.Даваадоньд (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Сайнбилэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

2.Хөрөнгийн үнэлгээ тогтоох ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100556